

Шинэ бүтээлд энэ махбод хамаагүй

Энэ дэлхий дээр байхдаа Есүс Христ Никодем гэдэг иудейчүүдийн нэгэн ахлагчтай уулзан, эрт дээр үеэс амлагдсан Хаант улсад орохын тулд “та нар дахин төрөх ёстой” гэжээ. Шинэ сүнстэй болох тухай энэ үнэ «Хуучин гэрээ»-ний, Израилд зориулсан эш үзүүлэлт дээр үндэслэсэн. Ингээд Есүс тухайн үед



“эцгүүдэд өгсөн амлалтуудыг батлахын тул... хозлуулагсдын [=еврейчүүдийн] зарц болсон” билээ (Ром 15:8).

Никодемтэй ярихдаа Есүс мөн: “Хэрэв Би та

нарт газрын юмсыг ярихад итгэхгүй бол, тэнгэрийн юмсыг ярихад минь та нар яаж итгэх юм бэ?” гэжээ (Иохан 3:12). Амлагдсан хаант улс өнөөгийн хөрст газар дээр байх учраас Израилын хувьд хөрст дэлхий чухал. Иймд Есүс тэдэнд “газрын юмсыг” ярьсан.

Харин “тэнгэрийн юмсыг” Есүс Паулд илчилж, Загалмай ба шинэ бүтээл дээр үндэслэсэн шинэ сайн мэдээг бүх үндэстнүүдэд мэдүүлэхээр түүнд даатгасан. Христийн загалмай дээр хуучин бүтээл Ертөнцийн Эзэний хувьд өнгөрсөн бөгөөд үхэгсдээс амилсан Христ шинэ бүтээлийн эхлэл болжээ. Энэ сайн мэдээнд итгэсэн хүн “Христ дотор” байхад тооцогдох учраас мөн адил шинэ бүтээл боллоо.



Энэ бүхнийг бид өмнөх нийтлэлд авч үзсэн.

Дээрх зүйлсийг эргэцүүлэн бодохоор Израилд ба үндэстнүүдэд зориулсан тэс өөр хоёр сайн мэдээ нь хүний махбод (АБ2004: “махан бие”) ба махбодод хамаатай зүйлсийг ч тэс өөрөөр хардаг нь ойлгомжтой. Энэ сэдвийн тал дээр илүү тод ойлголттой болохыг энэ нийтлэл зорино.

Дахин төрөхөд махбод чухал

Дахин төрөх гэдэг нь хуучныг шинэчлэхийг хэлдэг дүрслэл билээ. Шинэ юм бий болсон ч гэсэн тэр нь хуучны эд материалаар хийгдэнэ. Улмаар, төрөх нь өмнөх зүйлтэй махбодийн холбоосыг бий болгодог. Шинэчилсэн Израилыг Ертөнцийн Эзэн хуучин Израилын үр удмаас ба дахин амилсан еврей итгэгчээс бүрдүүлнэ. Иймд махбодоороо еврей хүн болж төрсөн байх нь Есүст итгэсэн еврейчүүдэд их чухал хэвээр. Махбоддоо хозлолын тэмдэгтэй (=хөвч хөндүүлсэн) байх нь маш чухал хэвээр. Дахин төрөх дээр тэдний махбодоос “чулуун зүрх” авагдах агаад оронд нь Их Эзэн тэдэнд “махан зүрх”-ийг өгөх билээ (Езекиел 36:22,26; АБ).

“Чулуун зүрх” нь зүйрлэлийн чанартай ч, өмнө нь байсан тэр л махбод израилчуудад байх хэвээр нь тодорхой.





Иймд мянган жилийн Хаант улсад Израил “махбодын хувьд” үндэстэн байх болно. Есүс Хаан хүртэл “махбодын хувьд” “Абрахамын удам, Давидын удам” гэж төрсөн нь тэр Хаант улсад Их Хаан нь болох эрхийнх нь үндэс юм (Ром 1:3; Матай 1:1). Түүний доор захирах хаад мөн адил израилын үр удмаар төрсөн хүн байх ёстой.

Петр болон бусад элч апостол нар Хаант улсын тухай сайн мэдээг зарласны төлөө ямар шагнал авах билээ? Есүс тэдэнд: “Үнэнээр Би та нарт хэлье. Хүний Хүү Өөрийн сүр жавхланта сэнтийдээ залрах үед Намайг

дагасан та нар ч мөн Израилийн арван хоёр овгийг шүүж, арван хоёр сэнтий дээр залрах болно”




гэж амласан (Матай 19:28). Хаант улсад Израилын нэг овгийг захирах сэнтий дээр залрахын тулд Петр өөрөө израил хүн байх ёстой нь мэдээж. Дахин амилсан ч тэр еврей хүн хэвээрээ. Эдгээр махбодийн холбоос Хаант улсад дэндүү чухал.

Харин шинэ бүтээлийнхэн хувьд “иудей ч гэж байхгүй, грек ч гэж байхгүй, боол ч гэж байхгүй, чөлөөт хүн ч гэж байхгүй, эр ч гэж байхгүй, эм ч гэж байхгүй. Учир нь та нар бүгд Христ Есүс дотор нэг болой” (Галат 3:28).



Паулын энэ үг Израилын мянган жилийн Хаант улсад тохирохгүй. Хаант улсад израильчууд бүх дэлхийг хаанчилж, Ертөнцийн Эзэн ба бусад үндэстний хооронд зуучлах болно (үүний төлөө шинэ сүмийн өргөө баригдана). Иймд хүн төрөлхтөн еврей, еврей бус гэж хуваагдсан хэвээр, махбод дээр үндэслэх тэр ялгаварлал хараахан арилаагүй байх болно. Израилын Хаант улс хуучин бүтээлд хамрагддаг учраас тэр.



Шинэ бүтээлд өнөөгийн махбод хамаагүй


Үүгээр хуучин бүтээлийг муулах гээгүй. Хуучин бүтээл өөрийн цаг үедээ чухал. Есүс махбодод амьдраад Загалмай дээр үхсэн нь үлэмжийн чухал. Хуучин бүтээлгүйгээр шинэ бүтээл гэж байхгүй (1 Коринт 15:44).

Харин Христ доторх шинэ бүтээл хуучин бүтээлийг ардаа орхисон байна. Хуучин бүтээл үндсээрээ завхарсан бөгөөд бүрэн засагдахын аргагүй болохыг Их Эзэн Паулд илчилсэн юм. Паул бичихдээ, “махбодод минь ямар ч сайн зүйл байдаггүйг би мэддэг. Яагаад гэвэл миний дотор сайныг хийх хүсэл байвч хийж чаддаггүй...”



Хэн намайг үхлийн энэ биеэс ангижруулах вэ? [Хайр ивээл!]¹ Бидний Эзэн Есүс Христээр талархал нь Бурханд байх болтугай” (Ром 7:18-25).

Гэм нүгэл оршдог “махбодийн үйлс” тодорхой (Галат 5:19-21). Ертөнцийн Эзэний бүтээсэн сайхан махбод нэгэнт гэм нүглээр ийм аймшигтайгаар завхарч, өтлөн үхдэг болсон учраас хуучин бүтээл тэр чигтээ Христтэй хамт Загалмайд цовлогдох шаардлагатай байв. Цоо шинэ бүтээлийн эхлэл нь Христийн амиллаар тавигдсан.



Үүнд итгэсэн бид Христтэй нэгдэж, одоохондоо “махбодод алхдаг” хэвээр ч гэсэн “Христийг өмссөн” Түүн шиг шинэ бүтээл болсонд тооцогддог (2 Коринт 10:3, Галат 3:27). Махбодийн үнэн байдлыг мэдсэн бид “махбодод түшиглэдэггүй” харин зөвхөн Христ Есүсээр сайрхдаг (Филиппой 3:3). Бид хуучин махбод дотор амьдарсан ч “махбодын дагуу бус, харин сүнсний дагуу” алхахаар дуудагдсан (Ром 8:4).

1 Энэ сайхан хариу Кодекс Синаитикус хэмээх грек Библийн хамгийн хуучны гар бичмэлээс олддог боловч ихэнх орчуулганд даанч ороогүй.



“Махбодийн дагуу” явах нь Их Эзэний биш, “хүний жишгийн дагуу” явахыг хэлнэ (1 Коринт 3:3). Харин бид харснаараа биш, Ертөнцийн Эзэний хэлсэнд итгэх итгэлээр амьдарч, “сүнсээр удирдуулах”-аар дуудагдсан.

Бид нэгэнт “хорвоогийн язгуур юмсын тухайд Христтэй хамт үхсэн” учраас энэ хуучин махбодтой хамаатай зүйл бидэнд чухал бус болсон. “Барьж ч, амсаж ч, хүрч ч болохгүй” гэх (хэрэглэснээр мөхөх тавилантай бүхний талаарх) хүний сургаал”-д бид ач холбогдол өгөхгүй (Холоссай 2:20-23).

Израилд өгөгдсөн Хууль ба зан үйл “хоол унд, эсвэл баяр, шинэ сар, [шаббат] амралтын өдрүүд”-ийнх нь хамт “ирж буй юмсын сүүдэр” төдий. Харин тэр сүүдрийг тусгасан “бие нь Христийнх”.

“Бүхэл биеийг үе мөч болон шөрмөсөөр хамтад нь холбон хангаж, Бурханы өсөлтөөр өсгөдөг Тэргүүн” болох Христээс бид зуурна (Холоссай 2:16-19).



Израилын тэмцэл махбодтой нягт холбоотой

Хаант улсад орохын тулд израилынхан Есүс Христийг Машиах Хаанаа гэж хүлээн авахаас гадна, “нарийн хаалгаар орохыг хичээ”-н, “гэмшилд зохистой үр жимсийг гарган”, итгэлээ батлах гэж сайн үйлс хийх ёстой. Өөрөөр хэлбэл, тэд амьдралаа засч, нэг



ёсондоо хуучин хүнээ сайжруулах ёстой. Эс тэгвээс Хаант улсаас хасагдана (Лук 13:24; Матай 3:8-10; Иохан 15:1-6; Иаков 2:26).

Есүс Их Эзэн израилынхны долоон чуулганд илгээсэн захидлаа ихэвчлэн “Би чиний ажил үйлс ба зүдрэл зүтгэл...ийг чинь мэднэ” гэсэн үгээр эхэлсэн. Тэгээд: “Гэвч надад чиний эсрэг зүйл байна... Анхны үйлсээ үйлд. Чи эс гэмшвээс, Би чам дээр очиж, дэнг чинь байрнаас нь зайлуулах болно...” гэх зэргээр зэмлээд бас л үйлсийн тухай ярьдаг (Илчлэл 2:2-3:).

Израилынхны сайн үйлсэд гэм нүглийн эсрэг тэмцээд даван туулах нь багтана. Өөрөөр хэлбэл, нүгэл оршдог махбодынхоо эсрэг тэмцэж, бие сэтгэлийн буруу хүслийг дарна. Иаковын бичсэнээр “бүх биеэ хазаарлах чадвартай” хүн “төгс” (Иаков 3:2).

Улмаар, нийгэмд буй гэм нүглийн эсрэг тэмцэж, бусдын эсэргүүцлийг тэвчих ёстой. Петр бичихдээ: “Христ нэгэнтээ махан биеэрээ зовсон тул та нар ч гэсэн ижил зорилгоор өөрсдийгөө зэвсэглэ. Яагаад гэвэл махан биеэрээ зовсон нэгэн нь нүгэл хийхээ больсон” гэжээ (1 Петр 4:1).



Үүнчлэн «Еврейчүүдэд» хэмээх захидал: “Өөрийнх нь эсрэг зогссон нүгэлтнүүдийн эсэргүүцлийг тэвчсэн Түүнийг [Христийг] санагтун. Тэгвэл та нар сэтгэлээр унахгүй, тэнхээгээ ч барахгүй. Нүглийн эсрэг




тэмцэлдээ цус урсгах хүртлээ та нар хараахан эсэргүүцээгүй байгаа...” (Еврей 12:3-4).

Бидний тэмцэл мах цусны эсрэг биш

Харин Паул: “бидний тэмцэл бол мах цусны эсрэг биш, харин энэхүү харанхуй ертөнцийн захирагчид, эрх мэдэл, хүчнүүд, тэнгэрлэг оршихуй дахь ёрын муу сүнслэг хүчний эсрэг билээ” гэжээ (Эфэс 6:12). “Мах цус” гэдэг нь “мах ба цусаар бүрдсэн хүн” гэсэн утгатай еврей хэллэг.

“Христ дотор” буй шинэ бүтээл болсон бид хуучин бүтээлд хамрагдах өөрсдийн ч, бусдын ч махбодийн эсрэг тэмцдэггүй учраас гэмийн эсрэг ч тэмцдэггүй. Бидний дайсан бол

эсэргүүцэгч
хүмүүсийг ашигладаг
заль мэх ихтэй
сүнслэг хүчнүүд.
Тийм учраас “бид
махбодод алхдаг ч,
махбодийн дагуу
дайтдаггүй”, “юмсыг
гадна байдлаар нь
хардаг”-гүй,
“махбодийн зэвсэг”-
ийг ч ашиглахгүй
харин “Бурханы
хүчит зэвсгээр...
цэцэрхлийг нурааж,





Бурханы мэдлэгийн эсрэг босогч алив бардамналыг устгаж, бодол бүрийг Христэд дуулгавартай болгохоор олзолдог” (2 Коринт 10:3-5, 7).

Эдгээр сүнслэг зэвсэгт Ертөнцийн Эзэний өгсөн үнэн, зөвт байдал, амар тайванд хүргэх эвлэрэл, авралын баталгаа, итгэл зэрэг тусгай хуяг дуулга ба ялангуяа “Бурханы үг болох Сүнсний сэлэм” ордог юм (Эфэс 6:14-17). Юу нь “Бурханы мэдлэгийн эсрэг” болохыг таньж мэдээд сүнслэг сэлмээ хэрхэн ашиглахаа ч мэдэхийн тулд бид Их Эзэний үгийг сайтар сурч авах нь гарцаагүй. Энэ тэмцэл юуны өмнө оюун бодолд явагдах бөгөөд Их Эзэний Паулаар дамжин илчилсэн үнэнг бусдад ч хуваалцаж, өөртөө ч хадгалахын төлөө явагдана.

Израилын Хаант улсын жаргал махбодынх

Израилын Хаант улс хуучин бүтээлд хамрагддаг учраас хүн төрөлхтөний эрж хайдаг бие сэтгэлийн жаргалаар дүүрэн байх болно. Бид энэ амьдралдаа бүгд сэтгэлээр удирдуулдаг биетэй, монголоор гэхэд “сэтгэлийн амьтан”. Бид урьхан цаг агаартай, дулаахан гэртэй, халуун цайтай, амттай хоолтой, өнгөлөг хувцастай, эрүүл биетэй, уянгалаг хөгжимтэй, тансаг үнэртэй сайхан орчинтой, зугаатай цэнгэлтэй бөгөөд дутах зовох ямар ч юмгүй байхыг хүснэ.

Израилын Хаант улсад эдгээр жаргал дээд хэмжээгээр, арвин хангалуунаар байх болно.



Тэр үед “дорноос хийгээд өрнөөс олноороо ирцгээж, тэнгэрийн хаанчлалд Абрахам, Исаак, Иаковтай хамт ширээнд тухлах болно” (Матай 8:11). Улмаар, Есүс Их Эзэн дагалдагч нартайгаа хамт Хаант улсад дарс ууна гэсэн (Матай 26:29).

Тийм ч учраас израилчуудын хувьд Хаант улс “хүсэл мөрөөдлийн газар” мөн. Тийш орохыг Петр “сэтгэлийн аврал” гэсэн нь тийм учиртай (1 Петр 1:9).

Гэтэл Паулын зарласан сайн мэдээнд хэзээ ч “сэтгэлийн аврал” юмуу өнөөгийн бие сэтгэлд таатай ивээлийн тухай гардаггүй. Харин “Бидний Эзэн Есүс Христийн Эцэг Бурхан... Христ дотор тэнгэрлэг оршихуй дахь алив сүнслэг ерөөлөөр биднийг ерөөжээ” (Эфэс 1:3). Шинэ бүтээлийнхэн “сэтгэлийн амьтан” биш, “амин сүнсний амьтан” буюу сүнсээр удирдуулсан хүмүүс болох учраас тэр (1 Коринт 15:44-50; жич: АБ “сэтгэлээр удирдуулсан бие”-ийг “төрөлх бие” гэж орчуулсан).

Шинэ бүтээлд тохирох сүнслэг олон ерөөл юутай яруу сайхан жаргалтай болохыг бид өнөөдөр төсөөлөхийн аргагүй.

Шинэ бүтээл хэнийг ч махбодын дагуу үзэхгүй

Израилынхан дахин төрсөн ч хүн бүрийг махбодын дагуу үзэх нь жам. Тэд өөрсдийгөө ч, бусдыг ч, Есүс Христийг хүртэл махбодын дагуу үздэг.





Есүс ямар удмаар төрсөн нь дэндүү чухал. Махбодод байхдаа Есүс юу хийсэн, юу заасан нь дэндүү чухал. Түүний заасныг сахьдаг байхыг бусад үндэстэнд зааж, махбодод нь усан баталгаа хүртээх даалгаврыг тэд аль хэдийнэ хүлээсэн байна (Матай 28:19-20).

Харин Паул махбодтой холбоотой даалгавар аваагүй (“Христ намайг баптисм хүртээлгэхээр илгээсэнгүй!”), харин шинэ бүтээлийн тухай “Загалмайн үг”-ийг тунхаглах эвлэрлийн үйлчлэлийг авчээ (1 Коринт 1:17-18, 2 Коринт 5:18-20).

Хуучин хүн төрөлхтөн Христтэй хамт Загалмайд цовдлогдсон учраас үгүй боллоо. Ертөнцийн Эзэний хувьд хуучин бүтээл аль хэдийнэ хүчингүй болсон учраас хүмүүсийн гэм бурууг тооцохоо больсон!! “Бурханы дагуу бүтээгдсэн” шинэ бүтээлд “нүгэлт махбод” байхгүй учраас тэр. Түүнд хүлээн зөвшөөрөгдөхийн тулд “хүний гараар хийлгэдэг” баптисмаас гадна хозлол ч хэрэггүй болсон (Галат 6:15). Христ дотор буй итгэгчид энэ сайхан ирээдүйн бодитойд итгэн одоо ч хэнийг ч махбодын дагуу үзэхгүй байхаар дуудагдсан. Тухайлбал:



“Нэг нь бүгдийн төлөө үхсэн тул бүгд үхсэн гэж бид ятгагдсан. Тэрээр бүгдийн төлөө үхсэн учраас амьд байгсад цаашид өөрсдийн төлөө бус, харин өөрсдийнх нь төлөө үхээд,



амилуулагдсан Түүний төлөө амьдарна.

Иймд үүнээс хойш бид хэнийг ч махбодын дагуу үзэхгүй. Хэдийгээр бид Христийг махбодын дагуу мэддэг байсан ч эдүгээ бид Түүнийг дахиад тийм байдлаар нь мэдэхгүй.

Тиймээс хэн нэгэн нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна. Энэ бүхэн Бурханаас ирдэг бөгөөд Тэрээр биднийг Христээр дамжуулан Өөртэйгөө эвлэрүүлсэн. Ийнхүү эвлэрлийн үйлчлэлийг бидэнд өгчээ. Учир нь Бурхан дэлхийг Христ дотор Өөртэйгөө эвлэрүүлж, тэдний гэм бурууг эс тооцсон...” (2 Коринт 5:14-19).

Иймд Христ дотор буй итгэгч Христийг махбодын дагуу үзэхээ болино. Есүс махбодод байхдаа Өөрийгөө байнга “хүний Хүү” гэсэн цолоор дууддаг байсан бол Паул Христийг хэзээ ч тэр цолоор дуудаагүй нь учиртай. Есүс хэрхэн Давид хааны удам болж энэ дэлхийд мэндэлсэн,



тэртээ үед юу хийсэн, иудейчүүдэд юу гэж заасан нь бидэнд сонирхолтой ч тийм чухал биш гэсэн үг. Энэ дэлхийд хийсэн зүйлийн дундаас Христийн Загалмай ба дахин амилал хамгаас чухал. Тэгээд “бүх тэнгэрийн дээр” өргөмжлөгдсөнөөс хойш Түүний юу гэж хэлсэн, одоо юу хийдэг нь анхаарлыг маань эзэмдэх нь зүйтэй (Холоссай 3:1-3).



Христ дотор буй итгэгч мөн өөрийгөө махбодын дагуу үзэхгүй, харин “Христтэй хамт Бурханы дотор нууцлагдсан” шинэ бүтээл гэж өөрийгөө харж сурна(Холоссай 3:3-4). “Амьд байгсад” бид “цаашид өөрсдийн төлөө амьдрахгүй”, өөрөөр хэлбэл хуучин хүнээ засч, өөрийгөө сайжруулах гэж хичээн зүтгэхгүй, харин хамаг анхаарлаа яруу алдарт Эзэндээ хандуулж Түүний төлөө л амьдарна (2 Коринт 5:15). Энэ сургаал сэтгэлд ямар их баяр хөөр төрүүлдэгийг төсөөлөхийн аргагүй! Тэгээд нэг мэдсэн чинь Түүний ариун Сүнс бидний амьдралд Өөрийн үр жимсээ ургуулна (Гатал 5:22).

Бусад бүх итгэгчдийг бид мөн адил махбодын дагуу үзэхгүй. “Христ дотор” буй хүмүүс бүгд адилхан цагаатгагдсан, адилхан байр суурьтай, бүгд Ертөнцийн Эзэн-Эцэгт шууд л хандах эрхтэй (Эфэс 2:18). Цорын ганц Зууч нь Есүс Христ Өөрөө (1 Тимот 2:5).

Христэд итгээгүй хүмүүсийг хүртэл бид махбодын дагуу үзэхээ болино. Христийн Загалмайн ажлаас болж Ертөнцийн Эзэн хүн төрөлхтөнтэй Өөрийн зүгээс сайндсан байна.

«Илчлэл» номд бичсэн аймшигт үйл явдал тохиолдох үед ч Ертөнцийн Эзэн дэлхийтэй эвлэрсэн байх нь хэвээр. Гэтэл дэлхий ба ялангуяа израилынхан нойрноосоо сэргэж, энэ агуу сайхан үнэнг мэдэж авахын тулд мартагдашгүй цохилт авахаас өөр аргагүй. Паулын тунхагласан Эвлэрэл ялангуяа шинэ бүтээлд зориулсан юм.



Махбодоо засах эсвэл бодлоо засах

Дүгнэж хэлэхэд, Есүсийн ярьсан дахин төрөлт нь Израил үндэстэн *махбодоороо ба махбодын дагуу* шинээр эхлэхийг хэлнэ. Төрөхөөр махбодийн холбоос бий болдог учраас тэр. Иймд Хаант улсын жаргал ихэвчлэн бие сэтгэлийн буюу махбодынх байх болно. Үүнчлэн Хаант улсад орохын тулд израилынхан махбодоор зүтгэн тэмцэх ёстой. Тэд явах замаа, хийдэг үйлсээ өөрчилж, махбодоо засч залруулах хэрэгтэй. “Ийм сул дорой махбодтой ч гэсэн би Хаант улсад орохоо баталгаажуулахын тулд яах ёстой вэ?” гэж тэд бодох ёстой.

Харин “шинэ бүтээл” болсон итгэгч үүнээс тэс өөрөөр бодно.

Тухайлбал: “Ийм сул дорой махбодтой намайг

Ертөнцийн Эзэн махбодийн дагуу харахаа больсон гэдгийг би явал илүү сайн ойлгох вэ?” гэж бодно.

Бид сүнсээрээ

энэ дэлхийд хамрагдахаа больж, Ертөнцийн Эзэний бүтээх цоо шинэ хүн төрөлхтөний эхлэл учраас тэр. Ирээдүйн шинэ бүтээлд бид хараахан оршин суугаагүй ч гэсэн одоо ч итгэлээр, сүнсээр “хуучин





хүн төрөлхтөнийг тайлж, шинэ хүн төрөлхтөнийг өмсөх”-дөө хэнийг ч махбодийн дагуу үзэхгүй байхад дуудагдсан. Өөрөөр хэлбэл, бид бодлоо, ойлголтоо тэр шинэ бүтээлтэй нийцүүлж амьдрах нь зөв.

Израилынхан махбодоо засах ёстой бол бид оюун санаагаа засах ёстой.



Энэ бол нэг бодлын хэцүү. Шинэ бүтээл одоогоор хаана ч харагдахгүй, мэдрэхүйн эрхтнүүд маань байнга л хуучин бүтээлийн шинж чанараар л бөмбөгддөг. Ганц хэдийг нь тооцоход: үхэл, гэм, бүтэлгүйтэл, сэтгэлээр унах, утгагүй байдал... Хуучин бүтээлийн “бодит байдал” тольноос биднийг ширтэн харж, хэвлэл мэдээллээр чихэнд хашгирч, хажууд буй хүнээр дамжуулан биднийг элэглэн дооглодог мэт. Гэтэл Ертөнцийн Эзэний бодлыг өөрийн юмуу энэ

хорвоогийн бодлоос илүүд үзэж сурсан бол Түүн шиг бодох нь улам амар болно.



Тэгвэл шинэ бүтээлийг бодоход баяр хөөр хэзээд сэтгэлд буухад бэлэн байх болно.

Бид “махбодын дагуу бус, харин сүнсний дагуу” алхдаг (Ром 8:4).

“Бид үзэгдэх зүйлээр бус, харин итгэлээр алхдаг” (2 Коринт 5:7). □

Дараагийн нийтлэлдээ үндэстнүүдээс бүрдэх, Христийн гайхалтай Биеийг авч үзэх болно. Онцгой сайн мэдээг хүлээн авч, тус Биед багтсан хүн бүхэнд онцгой тэнгэрлэг хувь заяа ч бий.

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Шинэ гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон. Өөрөөр тодорхойлоогүй бол «Хуучин гэрээ»-ний ишлэлийг энэ орчуулгаас авсан байх болно.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org